

Казах үндэстний “Кобыланд баатар” баатарлагийн туульсын
зарим дүрийн тухайд

Байгабилын РИЗА*
Монгол Улс, Улаанбаатар,
“Riza Officielle” компанийн
захирал

Email: rizabaygavil@gmail.com,
<https://orcid.org/0009-0004-7275-2364>

Received: December 06, 2025 | **Accepted:** December 15, 2025 | **Published:** December 30, 2025

Хураангуй: Казах үндэстний “Кобыланд баатар” баатарлагийн туулийн зарим дүрийн тухай тууль дахь дүрслэлээс жишээлэн авч, орчуулан тайлбарлажээ. Энэ дүрслэлээс казах баатарлаг туулийн онцлог, тухайн үндэстний соёл энэхүү туульд хэрхэн илэрсэн, ёс уламжлал, туульд дүрслэгдсэн зан заншил, уламжлал нь өнөө цагт хэрхэн хадгалагдсан болон устаж үгүй болсныг ажиглаж болно. Үүнээс гадна тухайн дүрээр дамжуулан казах түмний эр хүн, эхнэр хүнийг үзэх үзэл, андын тангаргийн талаар авч үзэв.

Түлхүүр үг: Казах тууль, Кобыланд дүрийн судалгаа, баатарлаг тууль, ёс уламжлал

On Some Characters in the Kazakh National Heroic Epic “Kobyland Hero”

RIZA Baygabil
Managing Director of “Riza Officielle” Company,
Ulaanbaatar, Mongolia

Abstract: This study delves into the portrayal of selected characters from Kobyland, the most widely disseminated and monumental heroic epic of the Kazakh people. Scholars regard this epic as originating in the 15th century, and to date, twenty-nine versions of Kobyland have been identified. This study explores the symbolic attributes and narrative functions of Kobyland and queen Kurtka within the epic tradition. The epic of Kobyland is characterized by having fewer mythical elements and more realistic depictions of events, making it notable as a historical epic. Through this epic, one can discern the defining qualities of the Kazakh hero, queen, and wife including steadfast

* © Г.Риза, 2025

loyalty in love, the virtues of womanhood, and the sacred bond of sworn brotherhood.

Keyword: *Kazakh epic- Kobylant- character analysis, Through this epic*

Казах үндэстний эртний уламжлалт утга соёлын гайхамшигт өв болсон олон баатарлаг туульсаас цар хүрээний хувьд, ард түмэнд тархан дэлгэрсний хувьд, бусдаас ялгарах онцлог шинжийнхээ хувьд хамгийн том тууль Кобыланд баатрын тууль юм.

Энэхүү туулийг цуглуулж, хэвлүүлэх ажил XIX дүгээр зуунаас эхэлжээ. Одоогоор бидэнд олдоод буй хорин есөн бүлэг бий бөгөөд үүний 26 бүлэг нь Кобыланд баатрын баатарлаг үйлийн тухай, үлдсэн 3 бүлэг нь түүний хүү Бөкенбай болон Кикбай нарын тухай юм.

Баатарлаг туульсаас тухайн үндэстний түүх туулж өнгөрүүлсэн амьдралыг харж болно. Зөвхөн түүхийн хэсгүүдийг дүрслэх бус тухайн үндэстний зуун зуун дамжсан өв уламжлал, хүсэл мөрөөдөл дүрслэгддэг. Энэ туулиас үнэнч зан, эр зоригт баатарлаг эрийн хайр сэтгэл, эхнэрээ хэрхэн хүндлэн хайрлаж буйг, эмэгтэй дүүгээ хайрлах, халамжлах ахын хайр, эцэг эхээ хүндэтгэн дээдлэх хүүгийн сэтгэл, анд найзын тухай, унасан газар угаасан усаа хэрхэн хайрлаж буй сэтгэлийн илрэл, баатрын хөдөлмөрч зан, хэлсэн амласан үгэндээ үнэнч байх гэх мэт хүмүүний эрхэм чанарууд харагдана. “Баатарлаг туулийг ард түмэн бүтээдэг бөгөөд ард түмний төлөө бүтээдэг. Түүнийг бүтээгч нь ч, өвлөн уламжлагч нь удам судар, хүмүүжлээрээ, ертөнцийг үзэх үзэл, аливаа зүйлд хандах хандлагаас нь ч харахад ард түмэнтэйгээ хамт өсөж, хамт яваа энгийн хүн байдаг” В.М.Жирмунский¹

Кобыланд баатар энгийн ардын хүү юм. Тэрбээр Каракыпшакын Токтарбай гэх баяны ганц хүү юм. Туульд өгүүлснээр:

“Сексенге жас келгенше
Бір бала көрмей Токтарбай
Қайғыменен қан жұтып,
Ақылынан адасқан.
Тоқтарбайдың зарына
Қалың қыпшақ қайысқан,
Әулие қоймай қыдырып,
Етегін шеңгел сыдырып,
Қабыл болған тілегі,
Жарылғандай жүрегі,
Аналықтай байбіше
Елуге жасы келгенде,
Көзім ашпай дениеден
Өтемін бе дегенде,
Сонда көрген арыстан.
Бірүл, бірқыз атадан:
Қыздыңаты Қарлығаш,

80 насыг зооглотлоо
Үрийн зулай үнэрлээгүй Токтарбай
Амьдын тамд унан
Ухаан санаа нь балартжээ
Токтарбайн шаналалд
Кыпшак түмэн ч мөн цөхөрч,
Мэддэг, чаддаг бүх хүнийг зорьж,
Хүн үлдээлгүй сандайчин,
Хүсэл нь ийнхүү биелэхэд,
Хагарах дөхжээ зүрх нь,
Аналык бүсгүй
Тавин насыг зооглосон ч,
Нүд нээгдэлгүй
Энэ хорвоогоос халих нь гэтэл,
Бурхнаас заяасан арслан билээ.
Нэг хүү, нэг охин:
Охины нэр Карлығаш

¹ Қазақ СССР Ғылым Академиясы М.О.Әуезов атындағы Әдебиет Және Өнер Институты. 1977.Ақсауыт.Алматы, 6 тал

Кобландыға қарындас.”²

Кобландын ганц охин дүү билээ”

гэх дүрслэлээс харахад Кобыланд бол энгийн нэгэн баян айлын хүү болон эцгийнхээ 80 насанд мэндэлсэн хүү юм.

Кобыланд баатарлагийн туульсын нэгэн том онцлогийг ажиглан харахад туулийн үйл явдалд домгийн шинж тун цөөн дүрслэгддэг. Үйл явдлууд яг л бодит амьдрал дээр өрнөх бөгөөд бусад үндэстэн, жишээлбэл: монгол баатарлаг туульс дахь үлгэр домгийн шинж энд үгүй юм.

Монгол туульст ихэнхдээ домгийн цаг үеийн тухайд ярьдаг бол энд “Эрт нэгэн цагт” гэж эхэлж байгаа юм.

Жишээлбэл:

“Алты жаскакелгенде
Арыстан тұған Коблан
Қазнадан қамқа киеді
Өзімнің еншім болсын деп,
Тобылғы менді тор атты
Енші қылып мінеді”³

Зургаан нас хүрэхдээ
Арслан лугаа төрсөн Коблан
Дуулгаар зэвсэглэн
Өөрийн минь хөрөнгө болог гээд
Толбот хүрэн морийг
Өөрийн болгож хүлэглэлээ.

Ингээд зургаан нас хүрч, өөрийн хүлгээ хүлэглээд эрийн цээнд хүрлээ хэмээн адуу манахаар явж гэнэ. Хээр газар адуу манаж явсан Кобыландад нэгэн чимээ сонсогдоход, тэрбээр энэ чимээ хаанаас гарч буйг дэргэдэх Естемисээс дахин дахин асуугаад зүгээр суулгаагүйд Естемис арга буюу ийнхүү өгүүлнэ: Тэр уулын цаана Кызылбасын нутаг бий. Көктим аймгийн хаан Кызылбасын Куртка гэх үзэсгэлэн төгөлдөр охин бий.

“Ай астына аспанға
Құрды бақанқақтырып,
Алтын теңге аттырып,
Теңгені атып түсірген
Құртқаны сұлу сол алар.
Соның дауысы бүл дауыс,”⁴

Саран доорх хязгааргүй уудамд
Шон зоож байрлуулаад,
Алтан зоос буудуулж
Зоосыг онож унагаасан нь
Үзэсгэлэнт Курткаг авна гэнэ.
Энэ чимээ бол түүний чимээ.

Ингээд тийшээ очихгүй байхыг яаж ч гуйгаад дийлээгүй Естемис зургаан настай Коблан баатрыг арга буюу явуулжээ.

Естемис хэлэхдээ:

“Қой шырағым, жассыңғой,
байна
Жіберүге қорқамын.

Хэрэггүй хүү минь, чи минь балчир
Явуулахаас би айж байна

² Қазақ ССР Ғылым Академиясы М.О.Әуезов атындағы Әдебиет Және Өнер Институты. 1977. Ақсауыт. Алматы, 15 тал

³ Қазақ ССР Ғылым Академиясы М.О.Әуезов атындағы Әдебиет Және Өнер Институты.1977. Ақсауыт. Алматы, 16 тал

⁴Қазақ ССР Ғылым Академиясы М.О.Әуезов атындағы Әдебиет Және Өнер Институты .1977.Ақсауыт..Алматы, 17 тал

Тілімді алсан, рұқсат жоқ,
нь,

Барған мен кезек келмес-ті,
Баланы көзге ілмес-ті,
Бағып жатқан Құртқаны
Шырағым тектен бермес-ті.
Отырып бұлар кеңесті”.⁵

Үгэнд минь орвол, зөвшөөрч чадахгүй

Очлоо ч боломж олдохгүй,
Хүүхдийг юман чинээ үзэхгүйд
Өсгөж өндийлгөсөн Куртка
Хүү минь, зүгээр өгөхгүй гэж
Хамт сууж ярилцав.

Хэчнээн хориглоод хориглоод Кобыланд хүү Естемист: “Ерөөлөө хайрла?” хэмээн хормойд нь ороогдон, эргэлдэж гуйсаар байв.

Дээрх дүрслэлд: Кобыланд баатартай хэдий хүндлэлтэй харьцаж буй боловч “Чи бол балчир хүүхэд” гэх тэр хэсэг нь баатар хэмээн бүрэн хүлээн зөвшөөрөөгүй, энгийн нэгэн ноёныхоо хүүтэй харилцаж буй харилцан яриа, домгийн бус бодит амьдралын үйл явдал дээр өрнөж буйг харуулж байна.

Баатрын хөдөлмөрч зан туульд багагүй дүрслэгдэнэ. Адуу манахаар явсан, олон сар жилээр адуу манасан гэх дүрслэлүүд нь түүний хөдөлмөрч зангийн бас нэгэн илрэл болж байна.

Тууль цааш үргэлжлэхдээ олон суу алдарт, хүч чадал, үлэмж биет баатрыг балчирхан хүү Кобыланд өөрийн хүчээр ялж, тавигдсан шаардлагуудыг биелүүлж баатрын шаардлагыг ханган Куртка эхнэрээ болгон авч буй үйл явдлаар өрнөнө. Баатарлаг туульст хатдын дүр онцгой ач холбогдолтой байх нь цөөнгүй бий. Тэгвэл казах туульст ч хацар гоо, үзэсгэлэн төгөлдөр гэж дүрслэгддэг ч үүнээс гадна хатан ухаанаар, тэвчээр, нөхрөө хүндлэх хүндэтгэл, ажилсаг хөдөлмөрч зантай Куртка бүсгүй нь зохиолын гол баатрын хамгийн үнэнч зөвлөх, туслах болон сайн найз нь болж дүрслэгддэгээрээ онцлогтой юм. Жишээлбэл: Кобыланд Куртка эхнэрээ болгон аваад нутаг буцах замд олон хоногийн газрыг туулан явж байтал хар замыг дагуулан адуун сүрэг 2 талд хуваагдан бэлчиж байв. Энэ үед үзэсгэлэнт Куртка сүйх тэргээр толгойгоо цухуйлгаж адуун сүрэг рүү харав. Адуун сүрэг дунд хөх алаг гүү нүдэнд нь тусахад, тэргээ зогсоогоод Кобланд хүүг “Хаан минь нааш ирнэ үү” хэмээн дуудаад гүүг хараад шинжив:

Мынау жатқан көп жылқы
Кімдікі-деп сұрады.
“Сонау тұрған биені
Мені берсенде алғын деп

хэмээн

Батырға әмір қылады.
Батыр Коблан күледі,
“Басымды окқа байлаған,
Сеніберсем, қыз Құртқа
Бір елдің малын алармын”- деп

байлаа гээд

Езу тартып күледі.

Энэ олон адуу
Хэнийх вэ? гэж асуув.
Тээр хэвтэж буй гүүг
Надаар солиод ч болов авагтун

Баатарт зарлиг болов.
Баатар Коблан инээгээд,
Амиараа дэнчин тавьсан,
Куртка чамайг өгвөл
Нэгэн улсын адууг бүгдийг нь авах

Элгээ хөштөл инээж гэнэ.

⁵ Қазақ ССР Ғылым Академиясы М.О.Әуезов атындағы Әдебиет Және Өнер Институты .1977.Ақсауыт. Алматы .18 тал

Осы жатқан көп жылкы
Немере тұған ағамыз
Сәлімбай байдыңжылқысы.
Жанындай менікөреді,
Не сұрасам береді”
Тағы Құртқа сөйлейді,
“Құлақ салып сөзіме
Берітаман кел дейді-
Тобылғымендітор атың
Жауға мініп шабуға
Жарамайды бұл,- дейді,-
Жан серік атың, сұлтаным,
Көкала бие ішінде
Көк бурыл құлын бар,
Жан серік атыңсол, дейді,-

тэр гэв.

Бұл сөзімді біл деді.-
Құртқаның сөзін сынарың,
Жылқысы болса ағанның,
Ала көр, бірақ сен” деді”⁶

Бэлчээрлэж буй энэ олон адуу
Садны маань ах
Салимбай баяных билээ.
Намайг амь шигээ л хайрладаг
Юу ч асуусан надад өгнө гэв.
Куртка дахин өгүүлрүүн:
Аан гээд үгийг минь
Ойртож ирээд сонс гэв.
Мэнгэт хүрэн бор морь чинь
Дайснаа дайлаар мордоход
Тэнцэх хүлэг биш байна, гэв
Хань болох хүлэг чинь
Хөх алаг гүүний хэвлийд
Хөх буурал унага бий,
Аминд чинь хань болох хүлэг чинь

Энэ үгэнд минь итгээд
Намайг сориод үзнэ үү,
Ахын чинь адуу юм бол
Авч хайрла баатар минь гэв.

Ийнхүү түүний хэлснээр тэр гүүг авахаар болж Куртка ийнхүү хэлнэ:
Унагалах тун дөхчихсөн тул замын ая даахгүй байх. Тийм учир хажууд нь хэнийг
ч ойртуулалгүй Куртка бүсгүй асарч, унагалахыг нь хүлээн зогсов.

Көкала бие төңбекшіп
Домаланып сұлады.
Түңшығып тұлпар қалар деп
Құртқаның жаны шығады.
Сонда жатып құлындап,
Бурыл тұлпар туады.
Тұяғын жерге тигізбей
Үстіндегі шешініп ,
Құртқа сынды сұлуың,
Алтын тонға орады.
Ауызын үріп сыпырып.
Маңдайынан иіскеп,
Сұлтанымының деп жан аты,
Күн түсірмей көзіне,
Жан тигізбей өзіне,
Үстіне шатыр тіккізді.
Үйін тігіп сол жерге,
Қырық күнге шейін Бурылға
Құлықтың сүтін емізді,

Хөх алаг гүү
Эвхрэн газарт хэвтэв.
Унага нь бүтчих вий гэж
Куртка санаа зовно.
Тийнхүү гүү унагалж
Буурал хүлэг төрлөө.
Туурайг нь газар хүргэлгүй
Өмсөж буй хувцсаа тайлаад
Үзэсгэлэнт Куртка
Алтан дээлдээ ороов.
Унаганы хамрыг цэвэрлээд
Магнай дээр нь үнэрлээд,
Хааны минь амин хүлэг гээд,
Нар үзүүлэлгүй,
Биед нь юу ч ойртуулалгүй,
Өөрт нь зориулан майхан хийлгэв
Тэнд нь гэр бариад,
Дөч хоног болтол нь унаганд
Шинэ унагалсан гүүний сүү өгөв

⁶ Қазақ ССР Ғылым Академиясы М.О.Әуезов атындағы Әдебиет Және Өнер Институты .1977.Ақсауыт. Алматы, 23 тал

Және кырык күн біткенше,
Қысырдың сүтін емізді,
Сексен күні біткесін,
Тоқсан күні жеткесін,
Маңқа, қолқа болмасын деп,
Жеміне қосып қыз Құртқа.
Қызыл дәрі жегізді,
Бурылға қыз Құртқа
Түндікпенен күн берді
Түтікпенен су берді,
Бурылға қыз Құртқа
Алтыннан жабу оюлап”⁷

Бас дөчин хоног дуустал
Сувай гүүний сүүг уулгав
Наян хоног болсны дараа
Ерэн хоног болгоод,
Аливаа өвчнөөс холуур бай гээд,
Үзэсгэлэнт Куртка
Эмийн ургамал идүүлэв.
Буурал моринд
Гагц тооноор нар тусгаж
Яндангаар ус өгөн,
Буурал моринд зориулан
Алтаар хээлсэн нэмнээ хийлээ.

Дээрх жишээнээс гол баатрын унах хүлэг ямар чухал болохыг, баатрын эрэлхэг энгийн нэгэн хүлэг хүлэглэх учиргүйг дүрслэн харуулж байгаа бөгөөд түүний хүч чадал хэмжээлшгүй их, энгийн нэгэн хүлэг биш гэдгийг Куртка бүсгүй буурал морийг хэрхэн харж хандан, уналгад, баатарг бэлтгэн байгаагаас харж болох юм.

Зохиолд дүрсэлснээр нар ч үзүүлэлгүй ийнхүү асарсан буурал морийг дөчин гурван хоног дутуу байхад Кобыланд баатрын шаардлагаар гаргаж ирдэг. Энэ үед төрснөөсөө хойш нар үзээгүй хүлэг Куртка бүсгүйг сундаллаад, тэнгэр өөд хоёр удаа дүүлэн, гурав дахь дээр нь Куртка бүсгүй биеийнхээ хүчээр арайхийж газарт буулгасан гэх дүрслэл нь буурал морины хүч чадлыг харуулахын зэрэгцээ Куртка бүсгүй ч мөн адил хүч чадал, бяр тэнхээтэй баатарлаг бүсгүй гэдгийг давхар гаргажээ.

Энд хүлгийн сайныг ийн харуулсан ч түүнтэй зэрэгцүүлэн Куртка бүсгүй морь сайн шинжиж, ямар нарийн аргаар асран, хүч чадлыг нь нэмж буйг, ухаан төгс бүсгүй болохыг олон талаас нь зэрэгцүүлэн дүрсэлсэн байна. Үүнээс гадна Куртка “Надаар солиод ч болов тэр хүлгийг аваарай” гэснээс харахад казах эмэгтэйчүүдийн нөхөртөө үнэнч, өөрийн аминаас илүү нөхрийнхөө сайн сайхныг бодсон үг, үйлдэл нь маш тодорхой харагдаж байна. Казах түмэнд морь уях, уналгад бэлтгэх, түүнийг сойх зэрэг нь зөвхөн эр хүний хийх ажил байсан бус үүнд бүсгүй хүний халамж хайр, арчилгаа тордлогоо бас чухал байр суурь эзэлдэг байсныг энэ туулиас харах боломжтой юм.

Дүгнэлт

Нэгдүгээрт: Энэ туульс нь казахын баатарлагийн туульсын онцлог шинжүүдийг хадгалан дүрсэлжээ. Үүнд: Казах баатарлагийн туульс нь үйл явдал, цаг хугацааны хувьд домгийн шинж агуулаагүй. Бодит үйл явдал, дүрслэлүүдтэй байна.

Хоёрдугаарт: Казах үндэстний болон тэдний охид, хөвгүүдийн бяр чадал, ур ухаан, үндэстэн, газар усныхаа төлөө хэрхэн амиа өгөн тэмцэж буйг тодорхой дүрслэн харуулсан эртний өв уламжлал болсон ховор нэгэн бүтээлүүдийн нэг бол

⁷ Қазақ ССР Ғылым Академиясы М.О.Әуезов атындағы Әдебиет Және Өнер Институты .1977. Ақсауыт. Алматы, 26 тал

“Кобыланд баатар” тууль юм.

Гуравдугаарт: “Кобыланд баатар” туулийн хэл найруулгын онцлог нь дүрийн ихэсгэлийг дүрийн биеийн хөгжил, баатрын үйл, хүлгийн явдлыг зүйрлэхдээ ихэвчлэн ашиглаж, түүгээр дамжуулан дүр дүрслэлийн онцлогийг илэрхийлжээ.

Дөрөвдүгээрт: Хүмүүжлийн үүргийн хүрээнд сургуулийн наснаас өмнөх хүүхдүүдэд Кобыланд болон бусад баатарлагийн туульсыг бага балчир наснаас нь ярих, цаашлаад бага ангийн сургалтын хөтөлбөрт тусган хичээл болгон заадаг нь үндэстний хувьд олон эерэг талтай байдаг билээ.

Тавдугаарт: “Кобыланд баатар” тууль нь бодит үйл явдал, түүхэн баримт, өвөрмөц дүрслэлтэй байна.

Зургаадугаарт: Казак баатарлаг туульс нь хүмүүжүүлэх үүргийг давамгайл гүйцэтгэсээр ирсэн бөгөөд казах үндэстний бүүвэйн дуунд хүртэл баатруудын тухай дуулдаг билээ. Тэрхүү баатрын баатарлаг үйлийг таниулах, цаашлаад баатрын дүрээр эр хүнийг таних, хатдын дүрээр эмэгтэй хүний сайн шинж чанарыг тодотгон эхнэр хүн хань ижлээ хэрхэн хүндэтгэх гэх мэт хүмүүжлийн асуудлуудыг сургасаар ирсэн байна.

Ном зүй

а). Монгол хэлээр

Катуу, Б. (2013). *Монгол туульсын судалгаа*. Улаанбаатар: Улсын хэвлэлийн газар. [Katu, B. Mongol tuul'syn sudalгаа [Research on Mongolian Epics]. Ulaanbaatar: National Publishing House. 2013.]

Катуу, Б. (2004). *Монгол туулийн дүрийн тогтолцоо*. Улаанбаатар: Мөнхийн Үсэг хэвлэлийн газар. [katuu, B. Mongol tuuliin дүрийн тогтолтсоо [The System of Characters in Mongolian Epic]. Ulaanbaatar: Mönkhiin Үсэг Publishing House. 2004.]

б). Гадаад хэлээр

Ақсауыт. (1977). *Ақсауыт*: Алматы: Жазушы баспасы. [Aqsauyt]. Almaty: Jazushy Publishing House. 1977.]

Кобыланды Батыр. (1941). *Кобыланды Батыр*: Алматы: Қазақтың Мемлекеттік Біріккен Баспасы. [Koblandy Batyr]. Almaty: United State Publishing House of Kazakhstan. 1941.]



Open access: This is an open access article distributed in accordance with the Creative Commons Attribution Non-Commercial (CC BY-NC 4.0) license, which permits others to distribute, remix, build upon this work non-commercially, and license their derivative works on different terms, provided the original work is properly cited, appropriate credit is given, any changes made indicated, and the use is non-commercial. See: <http://creativecommons.org/licenses/by-nc/4.0/>